



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/315

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн төвийн болон Булган, Үенч, Алтай, Манхан, Эрдэнэбүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулиудаас элсэлт авч ажилласан Хөгжим бүжгийн консерваторийн багш /Монгол улсын гавьяат багш/ Г.Ширчинбаатарт дэмжлэг үзүүлж 1.000.000 төгрөгийг олгосугай.

2.Уг зардалд шаардагдах 1.000.000 төгрөг /нэг сая/ -ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.25-д заасан “Залуучуудын хөгжлийг дэмжих” хөтөлбөрөөс тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ

Zax-A/315 Ch.  
02.01545